*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын Нийгмийн даатгалын хууль тогтоомж, бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч Бямбаагийн Мөнхбаярын
2024 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. "Салбарын хууль тогтоомж, стратегийн дунд, богино хугацааны нэгдсэн бодлогыг төлөвлөх, бодлогын удирдамжаар хангах, зохицуулах"** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1.** Нийгмийн даатгалын хууль тогтоомж, бодлогын шинэчлэлийн хүрээнд тооцоо судалгаа хийх, мэдээлэл бэлтгэх, холбогдох байгууллагуудтай харилцах | -Тооцоо судалгаа, мэдээлэл, баримт бичиг боловсруулсан хувь | - | 100% | - Нийгмийн даатгалын багц хууль, холбогдох хууль тогтоомжийн танилцуулга, нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотойгоор оюутан, суралцагчдын тоон мэдээлэл бэлдэх, нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хүрээнд холбогдох тайлан мэдээлэл боловсруулах ажилд хамтран оролцов.<br>- Монголбанкинд тэтгэвэр барьцаалсан зээлийн талаар, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс орон тооны бус олон нийтийн хяналтын зөвлөл, орон тооны бус мэргэжлийн хорооны бүрэлдэхүүнийг баталсантай холбогдуулан банкны системд нөлөө бүхий банкуудын холбогдох санхүүгийн болон үр дүнгийн тайлан, мэдээллийг ирүүлэх талаар албан бичгийг, БНЧУ-ын Нийгмийн хэргийн асуудал эрхэлсэн сайдад тэтгэврийн тогтолцоо, актуар тооцооллын чиглэлээр хамтран ажиллах саналыг тус тус хүргүүлж ажиллав. | 1-12 сар | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | **Арга хэмжээ 1.2.**<br>Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг эцэслэн тохиролцох, байгуулах чиглэлээр ажиллах | -Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 14 дэх шатны хэлэлцээ хийгдсэн | 100% | Хэлэлцэн тохиролцогч талууд Хэлэлцээрт 2024.10.29-ний өдөр гарын үсэг зурсан бөгөөд Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийн батлуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 1-12 сар | 100% |
| | Дэд арга хэмжээ 1.2.1. Айлын талтай Хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцох хэлэлцээг зохион байгуулах | -Хэлэлцээрийн төслийг боловсруулах шинжээчдийн ажлын хэсгийн уулзалтын тоо | - | 3 | 2024 оны эхний хагас жилд хэрэгжүүлсэн.<br>- Хэлэлцээрийн төслийг хэлэлцэх монгол-казахстаны шинжээчдийн Ажлын хэсгийн 3 удаагийн хэлэлцээг зохион байгуулсан. Үүнд: 15 дахь шатны хэлэлцээг 2024.02.21-ний өдөр, 16 дахь шатны хэлэлцээг 2024.04.26-ны өдөр, 17 дахь шатны хэлэлцээг 2024.05.22-ны өдөр тус тус цахим хэлбэрээр зохион байгуулж, талууд хэлэлцээний протоколыг гарын үсэг зурж албажуулсан.<br>- Хэлэлцээгээр Хэлэлцээрийн төслийг хоёр улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу дотооддоо хэлэлцүүлсэн саналуудыг тус бүрчлэн хэлэлцэн хэлэлцээрийн төсөлд тусгах, орос хэлээрх бичвэрийг эцэслэн хянасан. | 1-6 сар | 100% |
| | Дэд арга хэмжээ 1.2.2. Монгол Улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу Хэлэлцээрийн төслийг холбогдох яамдаас санал авч нэгтгэх, саналыг айлын талтай зөвлөлдөх | -Хэлэлцээрийн төслийг айлын талтай эцэслэн тохиролцсон эсэх<br>(Тийм:1/ Үгүй:0) | - | 1 | 2024 оны эхний хагас жилд хэрэгжүүлсэн.<br>- Хэлэлцээрийн төслийг Монгол Улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу хэлэлцүүлэх хүрээнд ХНХ-ын сайдын 2023.12.27-ны өдрийн 01/3462 дугаар бичгээр нийт яамдаас санал авахаар хүргүүлсэн бөгөөд яамдаас ирүүлсэн саналуудыг нэгтгэн боловсруулж, БНКУ-ын талтай зөвшилцсөн.<br>- Талууд Хэлэлцээрийн төслийг шинжээчдийн түвшинд эцэслэн тохиролцож, Казахстаны талаас 2024.04.26-ны өдрийн 30-73 тоот ноот бичгээр, Монголын талаас Гадаад | 1-6 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | харилцааны яамаар уламжлуулан 2024.04.30-ны өдрийн 01/1251 дүгээр албан бичгээр ноот бичгээр тус тус эцэслэн тохиролцсон хэлэлцээрийн төслийг солилцсон. | | |
| | Дэд арга хэмжээ 1.2.3. Олон улсын гэрээний тухай хуулийн дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх | -Хэлэлцээний төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн эсэх (Тийм:1/ Үгүй:0) | - | 1 | - Хэлэлцээрийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2024.06.06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, УИХ-ын холбогдох байнгын хороотой зөвшилцөхөөр шийдвэрлэсэн (ЗГ-ын 2024.06.06-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэл).<br>- ЗГХЭГ-ын 2024.08.15-ны өдрийн ХЭГ/1498 дугаар бичгээр УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Хэлэлцээрийн төслийг зөвшилцөхөөр хүргүүлсэн. | 5-7 сар | 100% |
| | Дэд арга хэмжээ 1.2.4. Олон улсын гэрээний тухай хуулийн дагуу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх | -Хэлэлцээний төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлсэн эсэх (Тийм:1/ Үгүй:0) | - | 1 | - Хэлэлцээрийн төслийг УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2024.10.16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, хуралдааны санал, дүгнэлт, 07 дугаар тэмдэглэл гаргаж ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 9-10 сар | 100% |
| | Дэд арга хэмжээ 1.2.5. Хэлэлцээрт гарын үсэг зурах, Хэлэлцээрийг соёрхон батлуулах бэлтгэл ажлыг хангах | -Хэлэлцээрийг соёрхон батлуулах бэлтгэл ажлын хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ, боловсруулсан баримт бичгийн тоо | - | 2 баримт бичиг | - Монгол Улсын Ерөнхий сайдын 2024.10.24-ний өдрийн 89 дүгээр захирамжаар Хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад олгосноор сайд Л.Энх-Амгалан, БНКУ-ын Тэргүүн шадар сайд Скляр Роман Васильевич нар Улаанбаатар хотноо 2024.10.29-ний өдөр гарын үсэг зурсан.<br>- Мөн БНКУ-ын хөдөлмөр, хүн амын нийгмийн хамгааллын төлөөлөл 2024.10.28-ны өдөр ГБХНХЯ-нд ажиллаж, хэлэлцээрийг хэрэгжүүлэх маягтын төслийг боловсруулсан.<br>- Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны | 11-12 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тайланг боловсруулан 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 01/1342 дугаар албан бичгээр ГХЯ, ХЗДХЯ-нд тус тус хүргүүлээд байна. | | |
| 3. | **Арга хэмжээ 1.3.** Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийг эцэслэн тохиролцох, байгуулах чиглэлээр ажиллах | -Хэлэлцээрийн төслийг боловсруулах шинжээчдийн ажлын хэсгийн уулзалтын тоо<br>-Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 4 дэх шатны хэлэлцээ хийгдсэн | 1 хэлэлцээ<br><br>2 баримт бичиг | - “Монгол Улс болон Оросын Холбооны Улс хооронд Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийн төслийг хэлэлцэх шинжээчдийн түвшний 4 дэх шатны хэлэлцээгээр тохирсны дагуу Хэлэлцээрийн төслийг Монгол Улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу хэлэлцүүлэх хүрээнд ХНХ-ын сайдын 2023.12.27-ны өдрийн 01/3463 дугаар бичгээр нийт яамдаас санал авахаар хүргүүлсэн бөгөөд яамдаас ирүүлсэн саналуудыг нэгтгэн боловсруулсан.<br>- Яамдаас санал авч зөвшилцсөн үр дүнгийн талаар Оросын талд 2024.06.07-ны өдрийн 01/1689, 01/1690 дугаар ноот бичгээр ГХЯ болон ОХУ-ын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тус тус хүргүүлэв. | 1-12 сар | 90% |
| 4. | **Арга хэмжээ 1.4.** Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улсын хооронд нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулах асуудлаар хэлэлцээ зохион байгуулах | -Хэлэлцээрийн төслийг боловсруулах шинжээчдийн ажлын хэсгийн уулзалтын тоо<br>-Боловсруулсан баримт бичгийн тоо | - | 2 хэлэлцээ<br><br>3 баримт бичиг | - Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улсын хоорондын Нийгмийн хамгааллын хэлэлцээрийн төсөл боловсруулах эхний шатны хэлэлцээг Улаанбаатар хотод 2024.02.27-28-ны өдөр, 2 дахь шатны хэлэлцээг Вена хотод 2024.05.28-29-ний өдрүүдэд тус тус зохион байгуулсан.<br>- Талууд 2 шатны хэлэлцээний протоколоор тохирсны дагуу албаны шугамаар харилцаж, хэлэлцээрийн төслийн талаар урьдчилсан зөвшилцөлд хүрсэн. Мөн албаны шугамаар харилцаж хэлэлцээрийг хэрэгжүүлэх Удирдлагын тохиролцооны төслийг боловсруулсан бол 2024 оны 12 дугаар сард багтаан маягтын төслийг боловсруулахаар ажиллаж байна.<br>- Талууд 3 дахь шатны хэлэлцээг 2025 оны 3 дугаар сард Улаанбаатар хотод хийж, дээрх баримт бичгүүдийг эцэслэн тохиролцохоор | 1-12 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төлөвлөсөн болно. | | |
| 5. | **Арга хэмжээ 1.5.** Монгол Улсаас бусад улс орнуудтай байгуулсан нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээрийг эмхэтгэх, цахим хэлбэрээр боловсруулах | -Цахим эмхэтгэлийг боловсруулсан гүйцэтгэлийн хувь | - | 100% | - Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчийн албан хэрэгцээнд зориулан Монгол Улсаас Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Унгар Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Бүгд Найрамдах Чех Улс, Бүгд Найрамдах Турк Улстай байгуулсан нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээр болон удирдлагын тогтолцоог хэлэлцээр байгуулсан 3 хэлээр эмхэтгэн цахим хэлбэрээр бэлтгэв (хуудасны тоо 255). | 1-12 сар | 100% |
| 6. | **Арга хэмжээ 1.6.** Монгол Улсын иргэдийн олноор оршин сууж байгаа улс орнуудын нийгмийн хамгааллын тогтолцоо, бусад улстай байгуулсан нийгмийн хамгааллын хэлэлцээрийг судлах, төсөл боловсруулах (БНСУ, Австрали Улс) | -Нийгмийн хамгааллын тогтолцоо судалсан орны тоо<br>-Боловсруулсан хэлэлцээрийн төслийн тоо | - | 3 судалгаа<br><br>2 төсөл | - Нийгмийн үйлчилгээний яамтай хэлэлцээг эхлүүлэх талаар мэдээлэл солилцох уулзалтыг 2024.11.28-ны өдөр зохион байгуулсан. Уулзалтаар эхний шатны хэлэлцээг 2025 оны 01 дүгээр сард хийхээр тохиролцсон болно. Түүнчлэн, Австралийн Холбооны Улстай нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулах хүрээнд ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024.11.05-ны өдрийн А/126 дугаар "Ажлын хэсэг байгуулах тухай" тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна. Энэ хүрээнд дээрх уулзалтын бэлтгэл ажлыг хангаж хэлэлцээрийн төслийн эхний хувилбарыг боловсруулан удирдлагад танилцуулж, Ажлын хэсэгт хүргүүлсэн.<br>- Бүгд Найрамдах Солонгос Улстай 2006 онд байгуулсан Нийгмийн хамгааллын хэлэлцээрийг шинэчлэх хүрээнд хэлэлцээрийн төслийг монгол-англи хэлээр боловсруулж удирдлагад танилцуулсан.<br>- Мөн Казахстан, Солонгос, Киргиз, Австрали улсын нийгмийн хамгаалал, тэтгэврийн даатгалын тогтолцооны мэдээллийг бэлтгэн удирдлагад танилцуулсан. | 1-2 сар | 100% |
| **Зорилт 2. "Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх, хамрагдалтыг нэмэгдүүлэх, цахимжуулах"** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7. | **Арга хэмжээ 2.1.** Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн “2.1.3.2. Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, их өгөгдөлд тулгуурлан, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран цахимаар авах боломжийг бүрдүүлнэ” зорилтын хэрэгжилтийн хангах чиглэлээр ажиллах | -Нийгмийн даатгалын үйлчилгээг цахимжуулах чиглэлээр зохион байгуулсан ажил, боловсруулсан баримт бичгийн тоо<br>-Ажлын хэсгийн уулзалтын тоо | - | 4 уулзалт<br>1 баримт бичиг | - Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024.10.21-ний өдрийн А/101 тушаалаар нийгмийн даатгалын үйлчилгээг их өгөгдөлд үндэслэн иргэдэд цахимаар үзүүлэх бэлтгэл ажлыг хангах Ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Батлан хамгаалах яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, “Үндэсний дата төв” УТҮГ, “И-Монгол академи” УТҮГ, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын төлөөллийг оролцуулан байгуулсан.<br>- Ажлын хэсэг 2024 оны 4 удаа хуралдаж, цахим хэлбэрээр үзүүлж байгаа НД-ын үйлчилгээний өнөөгийн байдал, тулгарч байгаа болон салбар хоорондын уялдааг хангах асуудлыг хэлэлцэж, тэтгэвэр тогтоолтын одоогийн процесс зураглалыг боловсруулж, дүн шинжилгээ хийв. Энэ хүрээнд хөдөлмөрийн чадвар алдсаны, ердийн болон олон хүүхэдтэй эхийн нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох хүсэлтийг цахимаар авах ажлыг туршин хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. | 10-12 сар | 90% |
| **Зорилт 3. “Хууль тогтоомж, бодлогын шинэчлэлийн хүрээнд тооцоо судалгаа хийх, нийгмийн даатгалын бодлогын төлөвлөлт хийх”** | | | | | | | |
| 8. | **Арга хэмжээ 3.1.** Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсэгт ажиллах | -Ажлын хэсгийн уулзалтын тоо | - | 2 уулзалт | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024.10.30-ны өдрийн А/48 дугаар тушаалаар байгуулагдсан Хувийн нэмэлт тэтгэврийн хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт ажиллаж байна. Ажлын хэсгийн эхний уулзалт 2024.11.06-ны өдөр болсон. Ажлын хэсгийн эхний уулзалтын протокол хөтлөх, хуулийн төсөлд санал өгөх чиг үүрэгтэй ажиллаж байна. | 11-12 сар | 70% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Нийгмийн даатгалын ирээдүйн чиг хандлагын талаарх мэдлэгээ дээшлүүлэх, судлах | -Сургалтад хамрагдаж, батламж авсан эсэх (Тийм:1/Үгүй:0) | - | 1 | - Дэлхийн банк, Солонгосын хөгжлийн хүрээлэн (KDI)-ээс хамтран тэтгэврийн системийн шинэчлэлд тулгарч байгаа гол асуудлуудыг олон улсын байр сууринаас болон БНСУ-ын туршлагаас хуваалцах "Тэтгэврийн бодлого ба хэрэгжилт" семинарт 2024 оны 04 дүгээр сарын 16-19-ний өдрийн хооронд хамрагдаж Монгол Улсын тэтгэврийн даатгалын тогтолцооны мэдээллийг танилцуулсан. Семинарт амжилттай оролцсон талаарх батламж авсан.<br>- БНСУ-ын Хамтын Ажиллагааны Байгууллага (КОЙКА) болон Солонгосын Үндэсний тэтгэврийн алба хамтран 2024.09.22-2024.10.02-ны өдрийн хооронд зохион байгуулсан "Өндөр настны тогтвортой орлогыг дэмжих тогтолцооны менежментийн чадавхыг бэхжүүлэх" сэдэвт 2 дахь удаагийн сургалтад хамрагдаж батламж авсан. | 4-9 сар | 100% |
| 2. | Бодлогын дүн шинжилгээ, үнэлгээ хийх ур чадвараа дээшлүүлэх, судлах | -Бие дааж суралцсан эсэх (Тийм:1/Үгүй:0) | - | 1 | MITx online цахим сургалтын платформоос нийгмийн хөтөлбөрүүдийн үнэлгээ (Evaluating Social Programs) хичээлийг 2024 оны 10-12 дугаар сард судалж дуусгасан (auditing). | 6-12 сар | 90% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

| | | |
|---|---|---|
| Нийгмийн даатгалын хууль тогтоомж, бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч | [signature] / Б.Мөнхбаяр / | 2024 12 05 |
| *( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Огноо )* |